



153

МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 400

Улаанбаатар хот

Хавдар судлалын үндэсний төвийн  
дүрэм, бүтцийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4, 21 дүгээр зүйлийн 21.2 дах заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хавдар судлалын үндэсний төвийн дүрмийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан бүтэц, дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллахыг Хавдар судлалын үндэсний төв /Л.Төмөрбаатар/-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /А.Эрдэнэтуяа/-д даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2007 оны 137 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Н.УДВАЛ



151  
Эрүүл мэндийн сайдын  
2013 оны 10 сарын 31 өдрийн  
400 дугаар тушаалын  
1 дүгээр хавсралт

## ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Хавдар судлалын үндэсний төв (цаашид Төв гэх) нь улсын хэмжээнд хавдрын төрөлжсөн тусламж, үйлчилгээ үзүүлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, мэргэжлийн дүгнэлт гаргах лавлагаа төв мөн.

1.2. Төв нь хүн амд улсын хэмжээнд хорт хавдрын чиглэлээр төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамж, аргачлал боловсруулах, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг давтан сургах, мэргэшүүлэх, эрүүл мэндийн бусад байгууллагыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах, хүн амын хорт хавдрын өвчлөл, тархалт, нас баралтыг тандан судлах, судалгаа, шинжилгээний ажил эрхлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах үүргийг хэрэгжүүлэх эрүүл мэндийн байгууллага юм.

1.3. Төв нь үйл ажиллагаагаа Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан стандарт, дүрэм, журмын дагуу явуулна.

1.4. Төв нь байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөтэй байна.

1.5. Төв нь Хавдар судлалын үндэсний төв, Улаанбаатар хот 210648, Баянзүрх дүүрэг, 18 дугаар хороо, Нам Янжуугийн гудамж гэсэн хаягтай байна.

1.6. Төвийн нэрийг англи хэл дээр "National Cancer Center" гэж орчуулна.

1.7. Төв нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас болон санхүүгийн харилцах данстай байна.

### Хоёр. Төвийн үйл ажиллагааны зарчим

2.1. Төв нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Үйлчлүүлэгчийг дээдлэх,
- Үйлчлүүлэгч бүрт эрх тэгш хандах,
- Хувь хүний эрх ашиг, нэр төрийг хүндэтгэн нууцлалыг сахих,
- Тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах,
- Тусламж, үйлчилгээтэй холбоотой шийдвэрийг нотолгоонд суурилан гаргах,
- Тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчид чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах,
- Ил тод, нээлттэй байж үйлчлүүлэгчийг шаардлагатай мэдээллээр хангах,
- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөх.

2.2. Төвийн эрхэм зорилго хавдрын мэргэжлийн тусламж, үйлчилгээг үйлчлүүлэгчид ээлтэй, чанартай, тэгш, хүртээмжтэй үзүүлэхэд манлайлагч байхад оршино.

2.3. Төвийн зорилго нь Монгол улсын хүн амыг хорт хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, хөнгөвчлөх тусламж, үйлчилгээний талаар төрөөс баримтлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах, зөвлөх, гүйцэтгэлийг хянах, тайлагнахад оршино.



2.4. Төвийн үйл ажиллагааны үндсэн зарчим нь хавдартай тэмцэх ажлыг өмчийн хэлбэрээс үл хамааран эрүүл мэндийн бүх шатны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, нийт хүн амын нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан явуулахад оршино.

### **Гурав. Төвийн эрх, үүрэг**

3.1. Төв нь дараах эрхтэй:

3.1.1. Хавдрын тусламж, үйлчилгээний чиглэлээр улсын хэмжээнд мөрдөгдөх хууль, дүрэм, стандарт, эмнэл зүйн удирдамжтай холбоотой санал боловсруулах, нотолгоонд суурилсан мэргэжлийн дүгнэлт гаргаж төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх,

3.1.2. Өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц, материаллаг болон хүний нөөц, төсвийг бүрдүүлж зохих хууль, тогтоомж, дүрэм, журмын дагуу захиран зарцуулах,

3.1.3. Ижил чиг үүрэг бүхий гадаадын лавлагаа төвүүдтэй хамтын ажиллагааг өргөжүүлэн хавдрын тусламж, үйлчилгээг сайжруулах, байгууллага болон хүний нөөцийг чадавхижуулах чиглэлээр хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, харилцан туршлага солилцох,

3.1.4. Судалгаа, шинжилгээг хөгжүүлэн, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинар зохион байгуулах,

3.1.5. Өөрийн орны болон гадаадын төрийн, төрийн бус, хувийн хэвшлийн байгууллага, иргэдтэй хамтран ажиллах, шаардлагатай тохиолдолд харилцан ойлголцлын санамж бичиг байгуулах,

3.1.6. Тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй, стандартын дагуу үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хөрөнгө оруулалтын асуудлаар төрийн захиргааны төв байгууллагад нотолгоонд суурилсан санал боловсруулан тавьж шийдвэрлүүлэх,

3.1.7. Хууль, тогтоомж, төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал шийдвэрийн дагуу тусламж, үйлчилгээг төлбөртэй үзүүлэх,

3.1.8. Хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх.

3.2. Төв нь дараах үүрэгтэй:

3.2.1. Бусад эрүүл мэндийн байгууллагаас холбогдох журмын дагуу шилжүүлсэн өвчтөнд хавдрын төрөлжсөн мэргэжлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, оношилгоо, эмчилгээний зөвлөмж, дүгнэлт гаргах,

3.2.2. Дараах чиглэлээр үндэсний хэмжээнд хавдрын төрөлжсөн мэргэжлийн лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлэх: тархи, мэдрэлийнхээс бусад бүх байрлалын хавдрын мэс засал, хавдрын туяа, хими болон хөнгөвчлөх эмчилгээ, хавдрын эс болон эдзүй судлал, хавдрын бүртгэл мэдээлэл,

3.2.3. Эрүүл мэндийн байгууллагын үзүүлж буй хавдрын тусламж, үйлчилгээний чанарт хяналт тавих, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх,

3.2.4. Хавдрын тусламж, үйлчилгээг сайжруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга хэмжээний санал боловсруулан төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах,

3.2.5. Хавдрын тусламж, үйлчилгээний чиглэлээр оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэл зүйн удирдамж, аргачлал боловсруулах,

3.2.6. Хавдрын тусламж, үйлчилгээний чиглэлээр төгсөлтийн дараах албан ба албан бус сургалтыг зохион байгуулах, бусад эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн баг ажиллуулан ажлын байрны болон зайн сургалт явуулах, шаардлагатай материалаг болон хүний нөөцийг бүрдүүлэх,



3.2.7. Тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулах, аюулгүй байдлыг хангах үүднээс зардлын хувьд үр ашигтай оношилгоо, эмчилгээний дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх,

3.2.8. Хавдрын чиглэлээр хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэгг үзүүлэх,

3.2.9. Хавдрын тусламж, үйлчилгээний чиглэлээр олон нийт болон зорилтот бүлгийн хүн амын дунд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд зохион байгуулах, холбогдох байгууллагыг арга зүйн удирдлагаар хангах, хамтран ажиллах,

3.2.10. Хавдрын тусламж, үйлчилгээний чиглэлээр хүн амын өвчлөлийн түвшин, тархалт, нас баралтыг судлах тандалтын тогтолцоог бий болгон мэдээний сан бүрдүүлэх, төрийн захиргааны төв байгууллага, хүн ам, бусад холбогдох этгээдийг мэдээллээр хангах,

3.2.11. Үйл ажиллагаандаа мэдээллийн технологийн дэвшлийг нэвтрүүлэн цахим эмнэлэг, цахим бүртгэл, цахим өвчний түүхийг ашиглах нөхцлийг бүрдүүлэх, алсын зайн анагаах ухааныг хөгжүүлэх,

3.2.12. Хавдрын тусламж, үйлчилгээний чиглэлээр эмнэлзүйн судалгаа шинжилгээг гүйцэтгэж, оношилгоо, эмчилгээний стандарт, удирдамжийг боловсронгуй болгоход шаардлагатай нотолгоог бий болгох,

3.2.13. Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлогын хүрээнд алсын хараа, хэтийн зорилгоо тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөө, байгууллагын дотоод журам, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх,

3.2.14. Үйлчлүүлэгчдийг эрүүл мэндийн болон өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангах,

3.2.15. Тусламж, үйлчилгээний талаарх үйлчлүүлэгчдийн санал, хүсэлт, гомдлыг шуурхай хүлээн авч шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх, санал гомдолд дүн шинжилгээ хийж залруулах арга хэмжээг үйл ажиллагаандаа тусган ажиллах,

3.2.16. Үзүүлж буй лавлагаа тусламж, үйлчилгээний чиглэлээр олон улсын түвшний итгэмжлэл авсан байх,

3.2.17. Санхүү, төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан санхүүгийн нөөцийн төлөвлөлтийн бодит, нотолгоонд тулгуурласан байдлыг хангаж үр дүнгийн хувьд ижил бол эдийн засгийн үр ашигтайг нь сонгон санхүүжүүлдэг байх,

3.2.18. Өөрийн үйл ажиллагааны онцлогийг тусгасан эрсдэлийн удирдлагын журам боловсруулж хэрэгжүүлэх,

3.2.19. Ажиллагсдын нийгмийн баталгааг хангах, ажлын байрны нөхцлийг сайжруулах талаар хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэн санаачлагатай ажиллах,

3.2.20. Ажиллагсдын мэдлэг, ур чадварыг байнга дээшлүүлж, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлж ажиллах,

3.2.21. Хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

#### **Дөрөв. Төвийн бүтэц, зохион байгуулалт**

4.1. Төвийн удирдлагын тогтолцоо нь Ерөнхий захирал, түүний дэргэдэх Удирдлагын зөвлөл, Эрдмийн зөвлөлөөс бүрдэнэ. Ерөнхий захирлын өдөр тутмын ажилд ажлын алба нь дэмжлэг үзүүлнэ.

4.2. Төвийн Ерөнхий захирлыг Эрүүл мэндийн сайд томилж, чөлөөлнө.

4.3. Төвийн Ерөнхий захирал нь эмчилгээ эрхэлсэн дэд захирал, эрдэм шинжилгээ, сургалт эрхэлсэн дэд захирал, стратеги төлөвлөлт, гадаад харилцаа



эрхэлсэн дэд захирал болон захиргааны нэгжийн удирдлагыг оролцуулсан Удирдлагын зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг тогтооно.

4.4. Төв нь судалгаа, шинжилгээний ажлын хэтийн болон ойрын зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, судалгаа шинжилгээ, эрүүл мэндийн технологийн үнэлгээний сэдэв, арга зүй, явц, үр дүнг хэлэлцэн, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт өгөх үүрэг бүхий Эрдмийн зөвлөл байгуулан ажиллуулна. Эрдмийн зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг Ерөнхий захирал батална.

4.5. Төвийн Ерөнхий захирал тушаал, Удирдлагын зөвлөл болон Эрдмийн зөвлөл нь хурлын тэмдэглэл гаргана.

4.6. Төв нь дэргэдээ Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, Эмэн эмчилгээг зохицуулах хороо, Санал гомдлын хороо болон бусад шаардлагатай зөвлөл, хороод байгуулан ажиллуулна.

4.7. Ерөнхий захирлын эрх, үүрэг:

4.7.1. Төвийг бүрэн хэмжээгээр төлөөлөх, үйл ажиллагааны үр дүнг хариуцах,

4.7.2. Төвийн бүтэц, алба, тасаг, бусад нэгжийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүрэг, байгууллагын дотоод журам, ойрын болон хэтийн стратеги төлөвлөгөө, байгууллагын хөгжлийн хөтөлбөрийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих,

4.7.3. Батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан Төвийн орон тоо, ажиллагсдын цалин хөлсийг тогтоох,

4.7.4. Дэд захирал, тасгийн эрхлэгч, албадын дарга нарыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу томилох, чөлөөлөх,

4.7.5. Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан, хэрэгжилтийн тайланг Төвийн хамт олны хурлаар хэлэлцүүлэн, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр иргэдэд мэдээлэх,

4.7.6. Ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлан, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, урамшуулах, сахилгын шийтгэл ногдуулах, гэрээг цуцлах,

4.7.7. Төсвийн ерөнхийлөн захирагчтай жил бүр Төвийн үйл ажиллагааны үр дүнгийн гэрээ байгуулж, биелэлтийг ханган ажиллах,

4.7.8. Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авилгаас ангид ажиллах,

4.7.9. Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийн үнэн зөв байдлыг хариуцах

#### **Тав. Төвийн санхүүжилт**

Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

5.1. Улсын төсөв,

5.2. Эрүүл мэндийн даатгал,

5.3. Үндсэн (хууль тогтоомжоор зөвшөөрсөн төлбөртэй тусламж, үйлчилгээний орлого) ба үндсэн бус үйл ажиллагааны орлого (байр, техник хэрэгсэл, бусад эд хөрөнгөө түрээслүүлсний орлого, бусад хууль тогтоомжид нийцүүлэн олсон орлого гэх мэт),

5.4. Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, хувь хүний хандив, тусламж,

5.5. Олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн санхүүжилт,

5.6. Хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэр.

#### **Зургаа. Гадаад, дотоод хамтын ажиллагаа**

6.1. Төвийг гадаад, дотоодод Ерөнхий захирал төлөөлнө.

6.2. Төвийн Ерөнхий захирлын гадаад оронд туршлага судлах, мэргэжлийн сургалтанд суралцах, хурал, семинарт оролцох албан томилолтыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар шийдвэрлэнэ.



6.3. Төвийн ажилтны гадаад, дотоодод албан томилолтоор ажиллах, суралцах асуудлыг Ерөнхий захирал шийдвэрлэнэ.

6.4. Төв нь төрийн захиргааны төв байгууллагын удирдлага, газрын дарга нартай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.

6.5. Төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй шууд харилцана.

## **Долоо. Төвийн дэд захирал, тасаг, албаны үйл ажиллагааны ерөнхий чиглэл**

### **7.1. Эмчилгээ эрхэлсэн дэд захирал**

Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг удирдан зохион байгуулна. Тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, аюулгүй байдал, эм, эмнэлгийн хэрэгсэл, цус, цусан бүтээгдэхүүний хангамж, зохистой хэрэглээ, осол, гамшгийн үеийн бэлэн байдлыг хариуцна.

### **7.2. Эрдэм шинжилгээ, сургалт мэдээлэл эрхэлсэн дэд захирал**

Хорт хавдраас сэргийлэх, хянах ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах, нийгмийн эрүүл мэндийн талаарх бодлого боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллана. Хавдар судлалын чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажил болон байгууллагын эмч, мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх, төгсөлтийн дараах сургалтыг удирдан зохион байгуулна. Хорт хавдрын бүртгэл, мэдээлэл, тандалт, байгууллагын мэдээллийн технологийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллана.

### **7.3. Стратеги төлөвлөлт, гадаад харилцаа эрхэлсэн дэд захирал**

Байгууллагын хөгжлийн урт, дунд хугацааны стратеги болон жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, Төвийн хэмжээнд хэрэгжих дүрэм, журам боловсруулах, хэрэгжилтэд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг мэдээлэх ажлыг зохион байгуулна. Шаардлагатай тохиолдолд Төвийн тодорхой чиг үүрэгт системчилсэн үнэлгээ хийж, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавина. Төвийн хүний нөөцийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг асуудлыг хариуцан ажиллана. Төвийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх ажлыг удирдан хэрэгжүүлнэ.

### **7.4. Ажлын алба**

Ерөнхий захирлын өдөр тутмын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ. Төвийн архив, бичиг хэрэг, хууль эрх зүйн тусламжийн асуудлыг хариуцна.

### **7.5. Чанарын алба**

Тусламж, үйлчилгээний чанарын удирдлагын тогтолцоонд нийцүүлэн чанарыг тасралтгүй сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулж, эрсдлийн удирдлага, чанар, аюулгүй байдалд дотоодын хяналт тавина.

### **7.6. Санхүү, эдийн засгийн алба**

Төвийн үйл ажиллагаанд шаардлагатай санхүүжилтийг бодитой тодорхойлох, байгууллагын хэмжээнд жилийн болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсвийн төслийг боловсруулах, байгууллагын үйл ажиллагааны үр дүн, үйл ажиллагааны нэгжийн өртөг зардлыг тооцох, төсвийн үр ашгийг сайжруулах арга хэмжээг авна.



159

Нягтлан бодох бүртгэлийн санхүүгийн тайлангийн олон улсын стандарт, Монгол улсад мөрдөгдөж байгаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн актуудын заалтад нийцсэн, харилцагч, хэрэглэгчийн шийдвэр гаргахад ач холбогдолтой, үнэн зөв мэдээллээр удирдлагыг хангана. Мөн санхүүгийн мэдээллийг цуглуулах, бүртгэх, тайлагнах, тодруулга бэлтгэх ажлыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүртгэл, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Хөндлөнгийн байгууллагаар гүйцэтгүүлэх санхүүгийн аудитыг зохион байгуулна.

#### **7.7. Хангамж, үйлчилгээ, инженер техникийн алба**

Төвийн барилга, цахилгаан, ус, дулаан хангамж, эд хогшил, эмнэлгийн тоног төхөөрөмж, автомашин, мэдээлэл, холбооны хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээг хийх, засвар үйлчилгээний холбогдолтой мэдээллийн сан байгуулж, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах, тасаг, нэгжүүдэд тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны журмыг мөрдүүлэх ажлыг зохион байгуулна. Гадаад болон дотоод орчны тохижилтыг хийж, байгууллагын харуул хамгаалалт, аюулгүй байдлыг хангана.

**7.8. Төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, хамтын ажиллагааны алба** Төвийн алсын хараа, хэтийн зорилгыг үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй уялдуулан тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх урт болон дунд хугацааны стратеги төлөвлөгөөг салбарын хэмжээнд дэвшүүлсэн бодлого, шийдвэртэй нийцүүлэн боловсруулна. Төвийн дотоод дүрэм, бүтэц, жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулна. Төвийн урт, дунд хугацааны болон жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, Төвийн үйл ажиллагааг сайжруулах талаар зөвлөмж гаргаж, удирдлагыг мэдээллээр хангана. Шаардлагатай тохиолдолд Төвийн тодорхой чиг үүрэгт системчилсэн үнэлгээ, хөрөнгө зарцуулалтын үр ашигтай, зохистой байдал, хууль, тогтоомж, стандарт, дүрэм журмын хэрэгжилтэд үнэлгээ хийж, хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнд үндэслэн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж гаргана. Төвийн гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлнэ.

#### **7.9. Хүний нөөц, хөгжлийн алба**

Салбарын хүний нөөцийн хөгжлийн бодлого, стратеги, хөтөлбөр, хууль, журам, тушаал, бусад шийдвэрийн хэрэгжилтийг байгууллагын түвшинд зохион байгуулах, байгууллагын хүний нөөцийн хэрэгцээг тооцож, төлөвлөх, төлөвлөгөө гарган хангалт, хуваарилалт, байршуулалт хийх, ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг боловсруулах, ажил үүргийн хуваарилалтад үнэлгээ хийх, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны стандартын хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтнийг тасралтгүй сургах, чадавхижуулах төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, багц цагийн баталгаажуулалт хийх, ажилтнуудын хувийн хэрэг, мэдээний санг хөтлөх, тогтмол баяжилт хийх, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэхээс гадна байгууллагын хүний нөөцийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэж, албан хаагчидтай холбоотой шийдвэр гаргахад удирдлагад дэмжлэг үзүүлж ажиллана.

#### **7.10. Нийгмийн эрүүл мэнд, эрдэм шинжилгээ, сургалтын алба**

Төвийн эрхлэх асуудлын хүрээнд үндэсний хэмжээнд хэрэгжиж буй хөтөлбөр, стратегийн хэрэгжилтийг манлайлан зохион байгуулах, өвчлөлийн түвшин, тархалтыг тогтоох тандалт, судалгаа явуулах, эрт илрүүлгийн бодлого, хөтөлбөр, удирдамжийг боловсруулах, эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлж, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийттэй хамтран ажиллана.



160

Хавдрын төрөлжсөн мэргэжлийн эмч, эмнэлгийн мэргэжилтний мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулна. Үндэсний түвшинд хавдрын статистик мэдээ, мэдээллийг цуглуулах, бүртгэх, мэдээлэх, дамжуулах, тайлагнах, мэдээний сан үүсгэх үйл ажиллагааг хариуцна. Мөн холбогдох байгууллагын бүртгэл, мэдээллийн ажилтанд тус чиглэлээр сургалт хийж, хяналт тавьж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

#### **7.11. Мэдээллийн технологийн алба**

Төвийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн оновчтой шийдлийг нэвтрүүлэх, эмнэлгийн цахим мэдээллийн тогтолцооны хэвийн үйл ажиллагааг хангах, мэдээллийн цахим сүлжээний аюулгүй байдлыг хангах, эмнэлгийн мэргэжилтний мэдээллийн технологийн мэдлэг, чадварыг нэмэгдүүлэх, алсын зайн анагаах ухааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлнэ.

**7.12. Мэс заслын клиник** (Ерөнхий мэс засал, элэг, цөс, нойр булчирхай, цээжний хөндий, толгой, хүзүү, эмэгтэйчүүдийн мэс заслын тасаг, мэдээгүйжүүлэг, хагалгааны тасаг, эрчимт эмчилгээ, яаралтай тусламжийн тасаг)

Тархи, мэдрэлийнхээс бусад бүх байрлалын хорт хавдрын оношилгоо, мэс заслын эмчилгээ болон мэс заслын дараах согогийн нөхөн сэргээх чиглэлээр үндэсний лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлнэ. Хавдрын мэс заслын үеийн мэдээгүйжүүлэг, хагалгааны явцын бэлэн байдлыг хангах, хагалгааны дараах сэрээх үйл ажиллагааг хариуцна. Яаралтай тусламж, хавдрын болон хагалгааны дараах өвчтөнд сэхээн амьдруулах, эрчимт эмчилгээ, тусламж, үйлчилгээг үзүүлнэ. Цус, цусан бүтээгдэхүүний зохистой хэрэглээ, аюулгүй байдлыг Төвийн хэмжээнд ханган ажиллана.

**7.13. Мэс заслын бус клиник** (Туяа болон хими эмчилгээний тасаг, Хөнгөвчлөх эмчилгээний сургалт, арга зүйн тасаг)

Бүх байрлалын хорт хавдрын туяа, хими, хөнгөвчлөх эмчилгээний чиглэлээр үндэсний лавлагаа тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

#### **7.14. Зөвлөх поликлиник**

Хавдрын төрөлжсөн мэргэжлийн лавлагаа тусламж, үйлчилгээ, хавдраас урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгийг зохион байгуулах, үр дүнг баримтжуулан, тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

#### **7.15. Онош зүйн тасаг**

Бүх байрлалын хорт хавдрын дүрслэл, үүнд рентген, хэт авиа, компьютерт томограф, уян дурангийн оношилгоо, эмчилгээг хийж, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэх үйлчилгээг үзүүлж, шаардлагатай дүрслэл оношилгооны арга, технологийг нэвтрүүлнэ.

#### **7.16. Нэгдсэн лабораторийн тасаг**

Биологийн болон эд, эсийн сорьцонд лабораторийн ерөнхий, нарийвчилсан шинжилгээ хийж, хавдрын эцсийн онош тогтоох, хяналтын шинжилгээ хийх үйл ажиллагааг эрхэлнэ.



#### **7.17. Сувилахуйн алба**

Сувилахуйн тусламж, үйлчилгээг хөгжүүлэх стратегийн хэрэгжилтийг хангах, сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, байгууллагын хэмжээнд сувилахуйн тусламж, үйлчилгээний стандартын хэрэгжилтийг хангах, хянах, заавар зөвлөгөө өгөх, сувилахуйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, халдвар хамгааллын дэглэм, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны горимын хэрэгжилтэд хяналт тавих, сувилахуйн тусламж, үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулах талаар санал, зөвлөмж боловсруулж арга зүйгээр хангаж ажиллана.

#### **7.18. Эмнэлгээс шалтгаалах халдвараас сэргийлэх алба**

Халдварын хяналт, ариутгал, халдваргүйтгэл, цэвэрлэгээ үйлчилгээг Төвийн хэмжээнд хийж, эмнэлгээс шалтгаалах халдвараас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох арга хэмжээ авна.

#### **7.19. Клиник эм зүйн алба**

Эмзүйн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангаж, эмчилгээний өндөр идэвхитэй, чанарын баталгаатай, аюулгүй, эдийн засгийн үр ашигтай эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангах, эмийн жор бичилт, зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмийн гаж нөлөөг бүртгэн мэдээлэх, нян эмэнд тэсвэржихээс урьдчилан сэргийлэх, шинэ эмийг эмчилгээнд нэвтрүүлэх, эмч мэргэжилтнийг эмийн мэдээллээр хангах үйл ажиллагааг зохион байгуулна.

#### **7.20. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний алба**


Хэвтэн эмчлүүлэгчдийн оношинд тохирсон эмчилгээний хоолоор хангах үйлчилгээг үзүүлнэ.

#### **Найм. Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах**

Төвийн Ерөнхий захирлын саналыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын тушаалаар дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулна.




Мэргэжил, арга зүйн удирдлагаар  
хангах ерөнхий зураглал



- Мэргэжил арга зүйн шууд удирдлага  
- - - - - Мэргэжил арга зүйн шууд бус удирдлага



# ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН БҮТЭЦ



Эрүүл мэндийн сайдын  
2013 оны 10 сарын 31 өдрийн  
400 дугаар тушаалын  
2 дугаар хавсралт